



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Батширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/98/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390</p> <p>Аудитор: Х.Еркегүл Утас: 99040705</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.2.1 Залруулсан алдаа	12
4.2.2 Төлбөрийн акт	12
4.2.3 Албан шаардлага	13
4.2.4 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13
6. Албан шаардлага	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

додд. 02.25 № 36
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Я.ОТГОНЧИМЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030043

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,316,160.03	133,839,333.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	85,570.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	85,570.19
3121	Төгрөг	-	85,570.19
31211	Төрийн сангийн харицах	-	85,570.19
33	АВЛАГА	-	92,558,009.22
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	43,509.22
335	Бусад авлага	-	92,514,500.00
3351	Байгууллагаас авах авлага	-	92,514,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,316,160.03	41,195,754.38
351	Түүхий эд материал	15,161,619.03	25,709,543.60
35130	Эм боох материал	15,161,619.03	25,709,543.60
354	Хангамжийн материал	19,659,541.00	12,541,210.78
35410	Бичиг хэргийн материал	312,970.00	217,940.00
35420	Аж ахуйн материал	16,909,331.00	11,679,670.78
35440	Түлш, шатах тослох материал	1,425,240.00	-
35460	Хүнсний материал	1,012,000.00	643,600.00
35600	Мал амьтад	4,495,000.00	2,945,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	337,862,781.79	363,020,135.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	337,862,781.79	363,020,135.84
392	Биет хөрөнгө	321,479,365.19	346,971,719.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	288,310,823.02	288,310,823.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,331,689.60)	(28,320,867.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,760,000.00	29,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,960,000.00)	(15,840,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,738,627.13	157,981,669.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(87,643,080.34)	(93,583,269.10)
39207	Тавигга, аж ахуйн эд хогшил	17,042,368.97	18,909,850.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,437,683.99)	(10,186,486.80)
393	Биет бус хөрөнгө	16,383,416.60	16,048,416.56
39301	Програм хангамж	1,345,000.00	1,345,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(379,583.40)	(714,583.44)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,418,000.00	15,418,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	377,178,941.82	496,859,469.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	29,791,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	29,791,600.00
413	Өглөг	-	29,791,600.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	29,791,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	377,178,941.82	467,067,869.63
51	Засгийн газрын хувь оролцоо	377,178,941.82	467,067,869.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	197,423,702.00	197,423,702.00
51101	Өмч: - төрийн	197,423,702.00	197,423,702.00
512	Хуримтлагдсан үр дүн	97,710,212.29	187,599,140.10
51210	Өмнөх үеийн үр дүн	97,710,212.29	97,710,212.29
51220	Тайланг үеийн үр дүн	-	89,888,927.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	82,045,027.53	82,045,027.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	377,178,941.82	496,859,469.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Давсны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	364,076,117.50	732,318,037.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,616,818.50	78,782,844.23
120	Нийтлэг татварын бус орлого	24,616,818.50	78,782,844.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,616,818.50	78,782,844.23
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,616,818.50	78,782,844.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339,459,299.00	653,535,193.00
1310	Удсын төвлөрсөн төсвөөс	296,899,200.00	395,221,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	296,899,200.00	395,221,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,940,939.00	212,553,103.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	121,800.00	24,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,582,000.00	200,734,303.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,237,139.00	11,794,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,946,800.00	22,215,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,946,800.00	22,215,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,672,360.00	23,545,390.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,672,360.00	23,545,390.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛЫН ДҮН	376,762,995.08	642,429,109.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,762,995.08	642,429,109.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,720,627.48	610,873,783.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,007,802.54	322,053,541.00
210101	Үндсэн цалин	144,442,028.51	158,972,956.26
210102	Нэмэгдэл	63,967,539.59	110,580,209.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,774,113.44	3,885,000.00
210104	Урамшуулал	14,824,121.00	35,312,055.12
210105	Гэрээт ажлын хөлс	-	13,303,320.00
2102	Ажлал олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,778,138.83	41,778,292.59
210201	Тэтгэврийн даатгал	20,219,234.83	29,616,384.27
210202	Тэтгэмжийн даатгал	834,031.00	2,884,598.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,793,300.00	2,593,833.48
210204	Ажил үйлдлийн даатгал	448,273.00	605,698.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,483,300.00	6,077,777.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,356,954.03	12,480,324.48
210301	Гэрэл, цахилгаан	2,286,454.03	2,704,008.48
210302	Түлш, халаалт	6,862,500.00	9,776,316.00
210303	Цэвэр, бохир ус	208,000.00	-
2104	Хангамж бараа материалын зардал	15,936,090.00	29,310,084.45
210401	Бичиг хэрэг	1,391,150.00	2,095,030.00
210402	Тээвэр, шатахуун	11,766,240.00	19,384,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,069,700.00	955,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,205,500.00	1,945,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	503,500.00	4,929,954.45
2105	Нормативт зардал	40,000,571.25	135,359,406.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,703,241.25	114,433,126.43
210502	Хоол, хүнс	9,297,330.00	15,320,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,606,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,021,930.00	3,485,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,930.00	341,550.00
210604	Урсгал засвар	968,000.00	3,143,550.00
2107	Томилголт, зочны зардал	2,500,000.00	3,432,500.00
210702	Дотоод албан томилголт	2,500,000.00	3,432,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлал, үйлчилгээний төлбөр, хураамж	13,429,279.00	812,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,810,699.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	65,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	61,400.00
210807	Газрын төлбөр	154,180.00	154,180.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,689,861.83	62,161,954.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,451,550.00	35,611,067.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	25,238,311.83	26,550,887.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,042,367.60	31,555,325.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,565,000.00	26,148,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,565,000.00	26,148,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	344,345.97	5,406,425.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	344,345.97	5,406,425.52
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,133,021.63	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,133,021.63	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(12,686,877.58)	89,888,927.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,686,877.58)	89,888,927.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,423,702.00	82,045,027.53	97,710,212.29	-	377,178,941.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	197,423,702.00	82,045,027.53	97,710,212.29	-	377,178,941.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,423,702.00	82,045,027.53	97,710,212.29	-	377,178,941.82
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	197,423,702.00	82,045,027.53	97,710,212.29	-	377,178,941.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	197,423,702.00	82,045,027.53	97,710,212.29	-	377,178,941.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	89,888,927.81	-	89,888,927.81
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,423,702.00	82,045,027.53	187,599,140.10	-	467,067,869.63

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	339,459,299.00	561,020,693.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	339,459,299.00	561,020,693.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	296,899,200.00	395,221,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,899,200.00	395,221,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,940,939.00	120,038,603.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	121,800.00	24,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,582,000.00	108,219,803.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,237,139.00	11,794,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,946,800.00	22,215,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,946,800.00	22,215,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,672,360.00	23,545,390.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,672,360.00	23,545,390.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	339,459,299.00	555,595,122.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	339,459,299.00	555,595,122.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,416,931.40	524,039,797.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,141,723.37	321,650,085.58
210101	Үндсэн цалин	140,905,389.66	143,629,667.20
210102	Нэмэгдэл	64,593,564.76	125,908,486.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,345,113.44	3,885,000.00
210104	Урамшуулал	14,297,655.51	34,689,954.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	13,536,978.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,236,900.00	41,971,157.23
210201	Тэтгэврийн даатгал	23,677,969.00	29,295,287.00
210202	Тэтгэмжийн даатгал	834,031.00	3,010,298.12
210203	ҮОМШӨ-нөй даатгал	1,793,300.00	2,414,038.49
210204	Ажигчидлийн даатгал	448,300.00	656,391.22
210205	Эрүүл мэндийн даатгал	4,483,300.00	6,595,142.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,514,454.03	13,785,324.48
210301	Гэрэл, цахилгаан	2,286,454.03	2,704,008.48
210302	Түлш, халаалт	7,020,000.00	11,081,316.00
210303	Цэвэр, бохир ус	208,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	16,051,180.00	24,808,710.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,931,480.00	16,653,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,069,700.00	955,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	350,000.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	3,398,850.00
2105	Нормативт зардал	28,120,355.00	82,346,413.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,857,725.00	68,031,733.00
210502	Хоол, хүнс	8,656,630.00	11,314,680.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,606,000.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,088,000.00	3,363,210.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	339,660.00
210604	Урсгал засвар	1,088,000.00	3,023,550.00
2107	Томилголт, зочны зардал	2,500,000.00	3,432,500.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	3,432,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,814,930.00	812,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,196,350.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	65,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	61,400.00
210807	Газрын төлбөр	154,180.00	154,180.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,949,389.00	31,869,817.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,949,389.00	31,869,817.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,042,367.60	31,555,325.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,565,000.00	26,148,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,565,000.00	26,148,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	344,345.97	5,406,425.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	344,345.97	5,406,425.52
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,133,021.63	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,133,021.63	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	5,425,570.19
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛЫН ДҮН (5)	-	5,340,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,340,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,340,000.00
223001	Бусад хөрөнгө	-	5,340,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(5,340,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	85,570.19
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхсийн үлдэгдэл	-	85,570.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	440,949,200.00	435,490,094.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,949,200.00	435,490,094.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,049,200.00	434,590,094.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,739,200.00	305,739,199.58
210101	Үндсэн цалин	165,685,400.00	138,218,781.20
210102	Нэмэгдэл	93,592,000.00	125,908,486.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,040,000.00	3,885,000.00
210104	Урамшуулал	24,852,800.00	24,189,954.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,569,000.00	13,536,978.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,660,100.00	40,658,657.23
210201	Тэтгэврийн даатгал	29,275,500.00	27,982,787.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,846,100.00	3,010,298.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,276,900.00	2,414,038.49
210204	Ажилгүйдлийн даатгал	569,200.00	656,391.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,692,400.00	6,595,142.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,980,300.00	13,785,324.48
210301	Гэрэл, цахилгаан	3,800,000.00	2,704,008.48
210302	Түлш, халаалт	14,516,300.00	11,081,316.00
210303	Цэвэр, бохир ус	664,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	24,813,100.00	24,808,710.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,655,100.00	16,653,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,358,000.00	955,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	3,398,850.00
2105	Нормативт зардал	34,250,100.00	34,233,013.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,250,100.00	22,233,033.00
210502	Хоол, хүнс	9,000,000.00	8,999,980.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,935,000.00	8,703,210.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,700,000.00	5,679,660.00
210604	Урсгал засвар	3,235,000.00	3,023,550.00
2107	Томилуулт, зочны зардал	2,150,000.00	2,150,000.00
210702	Дотоод албан томилуулт	2,150,000.00	2,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	822,000.00	812,580.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,000.00	65,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	65,000.00	61,400.00
210807	Газрын төлбөр	160,000.00	154,180.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,699,400.00	3,699,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,699,400.00	3,699,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900,000.00	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	900,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	440,949,200.00	435,575,664.48
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	395,221,400.00	395,221,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	395,221,400.00	395,221,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,215,300.00	16,808,874.48
132001	Орон нутгийн төсвөөс	22,215,300.00	16,808,874.48
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,512,500.00	23,545,390.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,512,500.00	23,545,390.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		85,570.19

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	120,038,603.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	120,038,603.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,789,703.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,910,886.00
210101	Үндсэн цалин	5,410,886.00
210104	Урамшуулал	10,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,312,500.00
210201	Тэтгэврийн даатгал	1,312,500.00
2105	Нормативт зардал	48,113,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,798,700.00
210502	Хоол, хүнс	2,314,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,282,500.00
210702	Дотоод албан томилолт	1,282,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,170,417.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,170,417.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,248,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,248,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,248,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	120,038,603.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,038,603.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	24,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,752,148.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,262,155.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Батширээт сумын ЭМТ нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 377.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119.7 сая төгрөгөөр буюу 31.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө		-	85.6	85.6
Авлага		-	92,558.0	92,558.0
Урьдчилгаа		-	-	-
Бараа материал		39,316.2	41,195.8	1,879.6
Үндсэн хөрөнгө		337,862.8	363,020.1	25,157.4
Нийт хөрөнгө		377,178.9	496,859.5	119,680.5
Өр төлбөр		-	29,791.6	29,791.6
Засгийн газрын сан /Орон нутгийн сан		197,423.7	197,423.7	-
Өмнөх үеийн үр дүн		97,710.2	97,710.2	-
Тайлант оны үр дүн			89,888.9	89,888.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		82,045.0	82,045.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		377,178.9	496,859.5	119,680.5
Нийт орлого /Үр дүнгийн тайлан		364,076.1	732,318.0	368,241.9
Нийт зардал /Үр дүнгийн тайлан		369,720.6	610,873.8	241,153.2

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 92.5 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41.2 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь короновируст халдварын үед хэрэглэх эм, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 363.0 сая төгрөг болж 25.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь дээд шатны байгууллагаас 6.8 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 38.7

сая төгрөг, батлагдсан төсвөөс 6.1 сая төгрөгийн худалдаж авсан үндсэн хөрөнгөөр нэмэгдэж, 4.6 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 197.4 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 732.3 сая төгрөг болж, өмнөх оноос 368.2 сая төгрөгөөр буюу 201.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 610.9 сая төгрөг болж, өмнөх оноос 241.1 сая төгрөгөөр буюу 165.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Энэ нь короновируст халдварын дэгдэлттэй холоотой илүү цагийн хөлс, урамшуулал, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд орон нутгийн төсвөөс 22.2 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 23.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 395.2 сая төгрөгийн санхүүжилт баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээс 395.2 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 23.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 22.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 435.5 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 98.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМДС-аас короновируст халдвараар гэрийн хяналтын санхүүжилт 9.1 сая төгрөг, тусгаарлах байрны хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилт 28.9 сая төгрөг, дархлаажуулалтын вакцины санхүүжилт 16.8 сая төгрөг, эрүүл мэндийн ажиллагсдад олгох нэг удаагийн тэтгэмжийн санхүүжилт 25.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11.8 сая төгрөг, эмийн хөнгөлөлтийн санхүүжилт 28.2 сая төгрөг зэрэг нийт 120.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагад төлөх эмийн зардлын 2026.5 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 222,529.1 мянган төгрөгийн 14 орлогын гүйлгээ, 26,893.8 мянган төгрөгийн 4 зарлагын гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 67 хувь байна. Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал бүртгэгдээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 251.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 2 албан шаардлага хүргүүлээ.

4.2.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.2.3 Албан шаардлага

1. Байгууллагад төлөх эмийн зардлын 2026.5 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй;
2. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 14 гүйлгээ 222,529.1 мянган төгрөг, зарлагын 4 гүйлгээ 26,893.8 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй орхигдуулж, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй; зэрэг зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

4.2.4 Зөвлөмж

Байхгүй

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Байгууллагад төлөх өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	2.0					1	2.0		
Дүн		1	2.0					1	2.0		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Шилэн дансны цахим хуудсанд 18 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;	1	249.4					1	249.4		
Дүн		1	249.4					1	249.4		
Нийт дүн		2	251.4					2	251.4		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 18/12370449
ХЭА-2022/98/НТ-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагад төлөх 2.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 -д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагад төлөх эмийн зардлын өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын ЭМТ-ийн дарга Я.Отгончимэг, нягтлан бодогч Э.Ононтунгалаг нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 17/А2370449
ХЭА 2022/98/НА-СГА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Батширээт сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 222.5 сая төгрөгийн 14 мөнгөн гүйлгээ, зарлагын 26.8 сая төгрөгийн 4 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын ЭМТ-ийн дарга Я.Отгончимэг, нягтлан бодогч Э.Ононтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА